



“Эрдэнэс-Тавантолгой” ХК

Огноо:

**МОДНЫ СУУЛГАЦ, МОД, ЗҮЛЭГ, НАРИЙН НОГООНЫ ҮР ҮРСЭЛГЭЭ, БИО
ЯЛЗМАГ, БОРДОО БУСАД УРГАМЛЫН УРГАЛТ ДЭМЖИГЧ ХАМГААЛАГЧ
БОДИС НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:	Модны суулгац, мод, зүлэг, нарийн ногооны үр үрсэлгээ, био ялзмаг, бордоо бусад ургамлын ургалт дэмжигч хамгаалагч бодис нийлүүлэгчийг сонгох
Харьцуулалт/ гэрээний дугаар:	ЭТТ/202001126

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Модны суулгац, мод, зүлэг, нарийн ногооны үр үрсэлгээ, био ялзмаг, бордоо бусад ургамлын ургалт дэмжигч хамгаалагч бодис** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим систем болох www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн өдрийн 10 цаг 40 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 1 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160
Утас: 75055555-504, Факс: 70118464,
Холбоо барих ажилтан: Ж.Даваажаргал**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																			
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> ➢ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ➢ Үнийн санал /нэр төрөл болон бүлэг тус бүрээр үнийн саналыг дэлгэрэнгүй ирүүлэх/ <table border="1" data-bbox="517 434 1294 846" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 5%;"></th> <th style="width: 75%;">Нэр</th> <th style="width: 20%;">Төсөв /мян.төг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">1</td> <td>Био ялзмаг, бордоо бусад ургамлын дэмжигч бодис</td> <td style="text-align: right;">9,600.0</td> </tr> <tr> <td style="text-align: center;">2</td> <td>Модны суулгац</td> <td style="text-align: right;">15,000.0</td> </tr> <tr> <td style="text-align: center;">3</td> <td>Мод, зүлэг, нарийн ногооны үр</td> <td style="text-align: right;">15,000.0</td> </tr> <tr> <td style="text-align: center;">4</td> <td>Үрсэлгээ</td> <td style="text-align: right;">5,000.0</td> </tr> <tr> <td style="text-align: center;">5</td> <td>Ургамал хамгааллын бодис</td> <td style="text-align: right;">1,500.0</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> ➢ Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ ➢ Татварын албаны цахим тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар, тендер нээсэн үеийн байдлаар өр төлбөргүй байх/ ➢ Тухайн чиглэлээр ажил, үйлчилгээ явуулж байсан талаархи компанийн танилцуулга ➢ 2018, 2019 онд ижил төстэй ажил гүйцэтгэж байсан 2-оос доошгүй гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн акт эсвэл тухайн газрын тодорхойлолт ирүүлэх. ➢ Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтсан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэх түүнтэй холбоотой аливаа эрсдлийг бүрэн хариуцхийг баталсан албан бичиг ирүүлнэ. ➢ Ургамал хамгааллын бодис худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй байх эсвэл тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай хамтарч ажиллах гэрээ ирүүлэх 			Нэр	Төсөв /мян.төг/	1	Био ялзмаг, бордоо бусад ургамлын дэмжигч бодис	9,600.0	2	Модны суулгац	15,000.0	3	Мод, зүлэг, нарийн ногооны үр	15,000.0	4	Үрсэлгээ	5,000.0	5	Ургамал хамгааллын бодис	1,500.0
	Нэр	Төсөв /мян.төг/																		
1	Био ялзмаг, бордоо бусад ургамлын дэмжигч бодис	9,600.0																		
2	Модны суулгац	15,000.0																		
3	Мод, зүлэг, нарийн ногооны үр	15,000.0																		
4	Үрсэлгээ	5,000.0																		
5	Ургамал хамгааллын бодис	1,500.0																		
ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим системд ирүүлэх																			
ТОӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 40 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.																			
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i>																			

1. Барааны тодорхойлолт:

БАГЦ-1. МОДНЫ СУУЛГАЦЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нөхөн сэргээлт мод үржүүлгийн талбайд тарих	ш	4410
2	2 га цэцэрлэгт хүрээлэнд тарих	ш	650
Нийт		ш	5060

Жич: Өмнөговь аймагт байршилтай Мод үржүүлгийн талбайгаас шинээр авсан байх, тээвэрлэлтэнд зориулж үндсийг гэмтээхгүйгээр битүүмжилж өөрийн чийгтэй хөрсөнд боож багласан байх шаардлагатай.

1. Нөхөн сэргээлт мод үржүүлгийн талбайд тариалах модны суулгацны задаргаа

Д/д	Модны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нас	Өндөр, м
1	Бургас	ш	200	2-3	0.7-1.0
2	Улиас	ш	300	2-3	0.7-1.0
3	Монос	ш	300	2-3	0.6-0.8
4	Тоорой	ш	10	2-3	0.4-0.6
5	Хайлаас	ш	200	2-3	0.6-0.8
6	Сухай	ш	300	2-3	0.4-0.6
7	Гүйлс	ш	300	3-4	0.4-0.6
8	Шар хуайс	ш	2600	2-3	0.5-0.8
9	Голт бор	ш	200	2-3	0.4-0.8
Нийт		ш	4410		-

2. Цогтцэций суманд байрлах 2 га талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнд тариалах модны суулгацны задаргаа

Д/д	Модны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нас	Өндөр, м
1	Улиас	ш	90	4-5	0.8-1.2
2	Монос	ш	90	4-5	0.7-1.2
3	Гүйлс	ш	90	4-5	0.7-1.0
4	Чацаргана	ш	190 (30ш эр, 160ш эм)	4-5	0.8-1.2
5	Хайлаас	ш	90	4-5	0.7-1.2
6	Голт бор	ш	100	4-5	0.7-1.0
Нийт		ш	650		-

**БАГЦ-2. МОД, ЗҮЛЭГ, НАРИЙН НОГООНЫ ҮРИЙН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ:**

Д/д	Мод, зүлэг, нарийн ногооны үр	кг	210.2
1	Модны үр	кг	51
2	Зүлэгний үр	кг	150
3	Нарийн ногооны үр	кг	9.2

Жич: Үрийн гарал үүсэл тодорхой, паспорттой байх.

1. Модны үр

д/д	Монгол нэр	Хэмжээ		Нийт үрийн эзлэх хувь	Цэвэршилт	Соёололт	Амьдрах чадвар
		Авах хэмжээ	- +				
1	Тоорой	5 кг	+1	9	95%	95%	95%
2	Монос	8 кг	+2	14	95%	95%	95%
3	Шар хуайс	6 кг	+2	12	95%	95%	95%
4	Гүйлс	10 кг	0	20	90%	90%	95%
5	Заг	5 кг	+2	9	95%	95%	95%
6	Сухай	10 кг	0	20	90%	90%	95%
7	Шинэс	3 кг	+1	7	90%	90%	95%
8	Нарс	4 кг	+1	9	90%	90%	95%

2. Зүлэгний үр




д/д	Монгол нэр	Хэмжээ		Нийт авах үрийн санд эзлэх хувь	1000 ш үрийн жин	Соёололт	Амьдрах чадвар
		Авах хэмжээ	- +				
1	Бор бударгана	30 кг	+5	20	3-4 гр	95%	95%
2	Таана	30 кг	+5	20	1,9 гр	95%	95%
3	Согоовор	10 кг	+5	8	3-4 гр	95%	95%
4	Ботууль	25 кг	+5	14	1,25 гр	90%	95%
5	Харгана	25 кг	+5	14	51-53 гр	95%	95%
6	Дэрс	10 кг	+5	8	3 гр	90%	95%
7	Ерхөг	10 кг	+5	8	2-2,4 гр	95%	95%
8	Царгас	10 кг	+5	8	2-3 гр	90%	95%

3. Нарийн ногооны үр


д/д	Монгол нэр	Авах хэмжээ	Үрийн сорт	Цэвэршилт	Соёололт	Амьдрах чадвар
1	Бууцай	1 кг	Матадор	95%	95%	95%
2	Юуцай	1 кг	Восточный экспресс	95%	95%	95%
3	Салат навч	1 кг	Гранд рапидс	95%	95%	95%
4	Редиск	0.5 кг	Карнавал	90%	90%	95%
5	Ногоон сонгино	0.5 кг	Нежный	95%	95%	95%
6	Яншуй	0.2 кг	Обыкновенная Листовая	90%	90%	95%



7	Төл сонгино	5 кг	Штутгартер ризен	95%	90%	95%
---	-------------	------	------------------	-----	-----	-----

БАГЦ-3. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИСЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ




Д/д	Бараа, ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт	Зураг
1	Каратэ-5 %	10 ш	Таримал ургамлын хортон шавжийн эсрэг инсектицид болох бодис. 1 литрийн савлагаатай.	
2	Фитоверм	20 ш	Таримал ургамлын хортон шавжийн эсрэг инсектицид болох бодис. 50 мл-ын савлагаатай байна. Олон төрлийн үйлчилгээтэй байна.	
3	Фитоспорин-М	40 ш	Таримал ургамлын өвчний эсрэг фунгицид биологийн бодис. 200 гр-ын савлагаатай байна. Олон төрлийн үйлчилгээтэй байна.	
Нийт		70 ш	-	



БАГЦ-4. ҮРСЛЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Үрслэгийн төрөл	Бортоготой	Тодорхойлолт
1	Өргөст хэмхийн үрслэг	530 ш	<p>Голланд эсвэл Америк сорт байх, 3-4 ширхэг жинхэнэ навчтай, өндөр 12-16 см, тод ногоон, жигд өнгөтэй байх, өвчин хортонд нэрвэгдээгүй эрүүл байх, үрслэгийн нас 40-50 хоног байна.</p> 
			<p>Голланд эсвэл Америк сорт байх, толстой сорт байж болно. 3-4 ширхэг жинхэнэ навчтай байх, өндөр 12-16 см өндөр, өнгө тод, жигд байх, өвчин хортонд нэрвэгдээгүй эрүүл байх, үрслэгийн нас 50-60 хоногтой байна.</p>

2	Лоолийн үрслэг	530 ш	
3	Гүзээлзгэний үрслэг	100 ш	<p>Зуны сорт байх, солонгос, хятад, япон улсынх байж болно. 3-4 ширхэг жинхэнэ навчтай, эрүүл өвчин хортонгүй байх, 2 ба 3-р үеийн эсвэл үрээр үржүүлсэн байх.</p> 
Нийт		1160 ш	

БАГЦ-5. БИО ЯЛЗМАГ, БОРДОО, БУСАД УРГАМЛЫН УРГАЛТ ДЭМЖИГЧ БОДИС, МАТЕРИАЛ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Д/д	Бараа, ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт	Зураг
1	Био ялзмаг	200ш	20 кг-ын савлагаатай, ургамлын өсөлтийг дэмжих, модны үрсэлгээ хийх, арчилгаанд ашиглахад тохиромжтой байх.	
2	Гумины бордоо	100ш	Бүх төрлийн таримал ургамал, ногоо, мод бут сөөг, хадлангийн талбай гэх мэт өргөн хэрэглээтэй байх /MNS 4456:2014/ 1000 гр-н савлагаатай хуурай.	
3	Шилмүүст модны бордоо (Здравень турво хвойный)	50 ш	Бүх төрлийн шилмүүст модонд ургалтыг сайжруулахаар хөгжлийн үе шатаас хамаарч өөр өөр тунгаар найруулж хэрэглэнэ. 150 гр –н савлагаатай хуурай.	

4	Биосил	10 ш	1 литрийн савлагаатай шингэн хэлбэрийн ургамлын өсөлт идэвхжүүлэх бодис.	
5	Гумат кали	10 ш	1 литрийн савлагаатай шингэн хэлбэрийн ургамлын өсөлт идэвхжүүлэх бодис	
Нийт		370 ш	-	

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ

3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]

4. **Бараа хүргэх газар:** [Эрдэнэс Тавантолгой ХК-ын Улаанбаатар хотын агуулах]

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тооширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Модны суулгац, мод, зүлэг, нарийн ногооны үр үрсэлгээ, биоялзмаг, бордоо бусад ургамлын ургалт дэмжигч хамгаалагч бодис	Техникийн тодорхойлолтын дагуу	4	бүлэг	ЭТТ компаний Улаанбаатар хот дахь агуулахад	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талыг төлөөлж захиалагчийн сонгосон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
 - 2) Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгэ, бусад шаардлагатай бичиг баримт
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын 5 хоногт төлнө.
- Урьдчилгаа төлбөр олгохгүй бараа нийлүүлсний дараа олгоно.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,1%]**
- Алдангийн нийт дүн: **[Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%- с хэтрэхгүй]**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг ____ оны __ дугаар сарын ____-наас ____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.